



ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО,
ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН ДАРГЫН
ТУШААЛ

2023 оны 03 сарын 20 өдөр

Дугаар А/25

Улаанбаатар хот

Зохион байгуулалтын бүтцийн
нэгжийн орон тоо, албан тушаалын
жагсаалт шинэчлэн батлах тухай


Засгийн газрын агентлагийн эрх зүйн байдлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.3.4, 8.4 дэх хэсэг, Хөдөлмөрийн тухай хуулийн 103 дугаар зүйлийн 103.3.1 дэх заалт, Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1 дэх заалт, Засгийн газрын 2020 оны 144, 2022 оны 488 дугаар тогтоол, Ерөнхий сайдын 2020 оны “Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын үйл ажиллагааны стратеги, зохион байгуулалтын бүтцийг шинэчлэн батлах тухай” 79 дүгээр захирамж, Төрийн албаны зөвлөлийн 2021 оны 07 дугаар “Шинэчлэн батлах, зөвшөөрөл олгох тухай” тогтоолыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1.Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын бүтцийн нэгжийн орон тоо, албан тушаалын жагсаалтыг хавсралтад заасны дагуу шинэчлэн баталсугай.

2.Энэхүү тушаал гарсантай холбогдуулан Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын даргын 2020 оны А/72 дугаар тушаалыг хүчингүй болсонд тооцсугай.


3.Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Захиргаа, удирдлагын хэлтэс /Н.Ганболд/-т даалгасугай.

ДАРГА



Б.ЦЭНГЭЛ

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын даргын 2023 оны 03 дугаар сарын 20-ны өдрийн 1/25 дугаар тушаалын хавсралт



ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО, ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН
 ЗОХИОН БАЙГУУЛАЛТЫН БҮТЦИЙН НЭГЖИЙН ОРОН ТОО,
 АЛБАН ТУШААЛЫН ЖАГСААЛТ

Д.Д	Албан тушаалын нэр	Албан тушаалын ангилал, зэрэглэл	Орон тоо
1. АГЕНТЛАГИЙН УДИРДЛАГА			
1	Дарга	Тэргүүн түшмэл ТЗ-1	1
НИЙТ			1
2.1. ЗАХИРГАА, УДИРДЛАГЫН ХЭЛТЭС			
1	Хэлтсийн дарга	Ахлах түшмэл ТЗ-4	1
2	Тогтоол, шийдвэрийн биелэлт хариуцсан ахлах мэргэжилтэн	Дэс түшмэл ТЗ-6	1
3	Дотоод ажил хариуцсан ахлах мэргэжилтэн	Дэс түшмэл ТЗ-6	1
4	Хүний нөөцийн мэргэжилтэн	Дэс түшмэл ТЗ-7	1
5	Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын мэргэжилтэн	Дэс түшмэл ТЗ-7	1
6	Хурлын зохион байгуулалт хариуцсан мэргэжилтэн	Дэс түшмэл ТЗ-7	1
7	Гадаад харилцаа, орон нутаг хариуцсан мэргэжилтэн	Дэс түшмэл ТЗ-7	1
8	Ерөнхий нягтлан бодогч	ТҮ-8	1
9	Тооцооны нягтлан бодогч	ТҮ-7	1
10	Даргын туслах	ТҮ-6	1
11	Архивын эрхлэгч	ТҮ-5	1
12	Бичиг хэргийн ажилтан	ТҮ-5	1
13	Нярав	ТҮ-4	1
14	Жолооч	ТҮ-3	2
НИЙТ			15
2.2. МЭДЭЭЛЭЛ, ТЕХНОЛОГИЙН АЛБА			
1	Албаны дарга	ТҮ-10	1
2	Мэдээллийн технологи хариуцсан ажилтан	ТҮ-7	1
3	Хэвлэл мэдээлэл, систем хариуцсан ажилтан	ТҮ-7	1
Нийт (алба)			3
Нийт (хэлтэс)			19
ГУРАВ. ХУУЛЬ, ЭРХ ЗҮЙН ХЭЛТЭС			
1	Хэлтсийн дарга	Ахлах түшмэл	1

		ТЗ-4	
2	Хуулийн ахлах мэргэжилтэн	Дэс түшмэл ТЗ-6	1
3	Хуулийн мэргэжилтэн	Дэс түшмэл ТЗ-7	3
Нийт			5
ДӨРӨВ. ТӨРИЙН ӨМЧИЙН УДИРДЛАГА, ЗОХИЦУУЛАЛТЫН ХЭЛТЭС			
1	Хэлтсийн дарга	Ахлах түшмэл ТЗ-4	1
2	Төлөвлөлт, хөрөнгө оруулалтын албаны Ахлах мэргэжилтэн /Албаны дарга/	Дэс түшмэл ТЗ-6	1
3	Удирдлага, төлөөллийн албаны Ахлах мэргэжилтэн /Албаны дарга/	Дэс түшмэл ТЗ-6	1
4	Төлөвлөлт, хөрөнгө оруулалтын асуудал хариуцсан мэргэжилтэн	Дэс түшмэл ТЗ-7	4
5	Удирдлага, төлөөллийн асуудал хариуцсан мэргэжилтэн	Дэс түшмэл ТЗ-7	4
Нийт			11
ТАВ. ТӨРИЙН ӨМЧИЙН БҮРТГЭЛ, АШИГЛАЛТЫН ХЭЛТЭС			
1	Хэлтсийн дарга	Ахлах түшмэл ТЗ-4	1
2	Төрийн өмчийн бүртгэл, ашиглалт хариуцсан ахлах мэргэжилтэн	Дэс түшмэл ТЗ-6	1
3	Орон нутгийн өмчийн бүртгэл, ашиглалт хариуцсан ахлах мэргэжилтэн	Дэс түшмэл ТЗ-6	1
4	Мэргэжилтэн	Дэс түшмэл ТЗ-7	8
Нийт			11
ЗУРГАА. ТӨРИЙН ӨМЧИЙН ХЯНАЛТ, ШАЛГАЛТЫН ХЭЛТЭС			
1	Хэлтсийн дарга	Ахлах түшмэл ТЗ-4	1
2	Төлөвлөлт, гүйцэтгэл хариуцсан ахлах мэргэжилтэн	Дэс түшмэл ТЗ-6	1
3	Хяналт шалгалт хариуцсан ахлах мэргэжилтэн	Дэс түшмэл ТЗ-6	1
4	Мэргэжилтэн	Дэс түшмэл ТЗ-7	5
Нийт			8
АГЕНТЛАГИЙН НИЙТ ОРОН ТОО			54